



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2020 оны 11 сарын 24 өдөр

Дугаар А/164

Улаанбаатар хот

Чиглэл батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 28.1.2 дахь заалт, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Сургуулийн өмнөх боловсролын сургалт, үйл ажиллагаанд баримтлах чиглэл"-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Батлагдсан чиглэлийг хэрэгжүүлж ажиллахыг өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэгийн эрхлэгч нарт даалгасугай.

3. Тушаалыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч ажиллахыг холбогдох албан тушаалтанд үүрэг болгосугай.

3.1 Батлагдсан чиглэлийн хэрэгжилтийг удирдлага зохион байгуулалтаар ханган, дэмжлэг үзүүлж ажиллахыг Сургуулийн өмнөх боловсролын газар /Ж.Мягмар/, нийслэлийн Боловсролын газар, аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын дарга нарт;

3.2 Батлагдсан чиглэлийг хэрэгжүүлэх арга зүйн сургалтыг сургуулийн өмнөх боловсролын багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн болон төрөлжсөн сургалтын агуулгад тусган зохион байгуулахыг Багшийн мэргэжил дээшлүүлэх институт /Ж.Болормаа/-д.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2014 оны "Тушаалын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" А/493 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Батбаатар/-т даалгасугай.

САЙД



Л.ЦЭДЭВСҮРЭН

142010588

Боловсрол, шинжлэх ухааны сайдын
2020 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн
А/164 дүгээр тушаалын хавсралт



СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Хүүхдийн цэцэрлэг/цаашид “цэцэрлэг” /-ийн сургалт, үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулахад энэхүү чиглэлийг баримтална.

1.2. Энэхүү чиглэл нь цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт, хүүхэд болон багшийн хөгжлийг дэмжих, эрүүл, аюулгүй, хүртээмжтэй сургалтын орчин бүрдүүлэх, эцэг эх, асран хамгаалагчийн оролцоо, хамтын ажиллагааг хангах асуудлыг тус тус хамарна.

1.3. Чиглэлийг хэрэгжүүлэхэд хүүхдийн хөгжих, эсэн мэнд амьдрах, хамгаалагдах, оролцох эрхийг хүндэтгэх, хүүхэд бүрд боловсрол эзэмших тэгш боломж олгох, сургалт, үйл ажиллагааг хүүхэд бүрийн онцлог, ялгаатай байдлыг харгалзан олон хувилбартай, уян хатан арга хэлбэрээр зохион байгуулах, хүүхдийн сурах, хөгжих үйлийг дэмжихэд бүх талын оролцоо, түншлэлийг хангасан, ил тод, нээлттэй, ялгаварлан гадуурхалтаас ангид байх зарчим баримтална.

1.4. “Сургалт, үйл ажиллагаа” гэж батлагдсан сургалтын хөтөлбөрийн дагуу цэцэрлэгийн анги танхим болон танхимын бус орчинд зохион байгуулагдах хүүхдийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааг ойлгоно.

1.5. Энэ чиглэлийн 3.11.2-т заасан “Бүлгийн менежмент” гэж сургалт, үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, үнэлэх, хүүхэдтэй харилцах, тэдний оролцоог хангах, идэвхжүүлэхэд оновчтой арга хэлбэр ашиглах, сургалтын орчин бүрдүүлэх, бүлгийн ерөөний зохион байгуулалт хийх зэрэг асуудлаар өөрийн онцлог бүхий арга, технологи боловсруулан төлөвлөж, хэрэгжүүлэхийг ойлгоно.

Хоёр. Цэцэрлэгийн хөгжлийн төлөвлөлт

2.1. Цэцэрлэг нь байгууллагыг хөгжүүлэх дунд, богино хугацааны төлөвлөгөөтэй байна.

2.1.1. Дунд хугацааны төлөвлөгөөг 5 жил, богино хугацааны төлөвлөгөөг 1 жилээр төлөвлөх;

2.1.2. Сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжлийн хэрэгцээ, сургалтын талаар баримтлах бодлого болон сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилтод нийцүүлэн цэцэрлэгийн эрхэм зорилгыг дунд хугацааны төлөвлөгөөтэй уялдуулан тодорхойлох;

2.1.3. Цэцэрлэгийн эрхэм зорилго нь хүүхдийн хөгжлийг дэмжихэд юу эрхэмлэх, сургалт, үйл ажиллагааг ямар арга хэлбэрээр, хэрхэн чанартай зохион байгуулж, ямар үр дүнд хүрэхийг илэрхийлсэн, хэмжиж болохуйц, бодитой, тодорхой байх;

2.1.4. Дунд хугацааны төлөвлөгөөг үндэслэн нэг жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулна.

2.2. Энэ чиглэлийн 2.1.4-д заасан төлөвлөгөө боловсруулах ажлыг хичээлийн жилд дэвшүүлэх зорилго тодорхойлохоос эхэлнэ.

2.2.1. Хичээлийн жилийн зорилгыг хүүхэд бүрд суралцах тэгш боломж олгох, сургалт, үйл ажиллагааны агуулга, арга зүй, технологийг боловсронгуй болгох, багш, ажилтны мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх, хүүхдэд ээлтэй сургалтын орчин бүрдүүлэх, эцэг эх, асран хамгаалагчийн оролцоог хангах замаар хүүхдийн хөгжил, төлөвшилд ахиц гаргах зэрэг асуудлуудаас тухайн хичээлийн жилд нэн тэргүүнд тэргүүлэх ач холбогдол өгөх чиглэлийг тодорхойлж, хэрэгжүүлэх;

2.2.2. Хичээлийн жилийн зорилго, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баримт нотолгоонд тулгуурлан багш, ажилтны оролцоотой боловсруулж, хэрэгжилтийг хангах;

2.2.3. Хичээлийн жилийн зорилго нь цэцэрлэгийг хөгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөтэй уялдсан, эрхэм зорилгоо дэмжсэн, бүрэн хэрэгжихүйц байх;

2.2.4. Тухайн хичээлийн жилд дэвшүүлсэн зорилго, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хичээлийн жилийн эцэст үнэлж, үр дүнг багш, ажилтанд нээлттэй танилцуулах бөгөөд энэ нь дараагийн хичээлийн жилийн зорилго, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах үндэслэл болгох.

Гурав. Сургалт, үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт

3.1. Сургуулийн өмнөх боловсролыг үндсэн болон хувилбарт сургалтын хэлбэрээр зохион байгуулах бөгөөд үндсэн сургалтыг цэцэрлэгт хамрагдаж буй хүүхдэд, хувилбарт сургалтыг үндсэн сургалтад тогтмол хамрагдаж чадахгүй байгаа хүүхдэд зориулан тус тус зохион байгуулах;

3.2. Үндсэн сургалтыг жил бүрийн 9 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл цэцэрлэгийн орчинд, хувилбарт сургалтыг танхим болон гэр бүлийн орчинд дагнасан болон хосолсон хэлбэрээр зохион байгуулах;

3.3. Үндсэн сургалтад хамрагдаж байгаа хүүхэд цэцэрлэгийн орчинд дасан зохицох хугацааг тэдний нас, хөгжлийн онцлогийг харгалзан 2-4 долоо хоног байхаар төлөвлөх;

3.4. Хувилбарт сургалтын нүүдлийн бүлгийн сургалтыг танхимд 8 долоо хоног, явуулын багшийн сургалтыг гэр бүлийн орчинд тус тус зохион байгуулах;

3.5. Явуулын багшийн сургалтад 3-5 настай хүүхдийг хамруулах бөгөөд 3 настай хүүхэд 80 цаг, 4 настай хүүхэд 100 цаг, 5 настай хүүхэд 120 цаг (15-20 минутыг 1 цаг гэж тооцох)-ийн агуулгыг хичээлийн жилд эзэмшүүлэх;

3.5.1. Явуулын багшийн сургалтын төлөвлөгөөг эцэг эх, асран хамгаалагч, явуулын багш хамтран хэрэгжүүлэх бөгөөд явуулын багш тухайн хичээлийн жилд сургалтад хамрагдаж байгаа нэг хүүхэдтэй ажиллах хугацааг сард хоёроос доошгүй удаа байхаар тооцох;

3.5.2. Гэр бүлийн орчинд хүүхдийн хөгжлийг дэмжин ажиллаж байгаа байдлыг хүүхэдтэй ярилцах, дасгал гүйцэтгүүлэх, хувийн хавтастай танилцах зэрэг арга хэлбэрээр тэдний хөгжлийн ахиц өөрчлөлтийг явуулын багш тандан, эцэг эх, асран хамгаалагчдад зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;

3.5.3. Эцэг эх, асран хамгаалагч нь явуулын багшийн өгсөн зөвлөгөөний дагуу гэр бүлийн орчинд хүүхэдтэйгээ ажиллах бөгөөд хүүхдийн хувийн хавтас бүрдүүлэх;

3.5.4. Энэ чиглэлийн 3.4, 3.5-д заасан сургалт зохион байгуулахад боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан, хүчин төгөлдөр мөрдөж байгаа “Бага насны хүүхдийг гэр бүлийн орчинд хөгжүүлэх хөтөлбөр”-ийг баримтлах;

3.6. Үндсэн болон хувилбарт сургалтыг зохион байгуулахад боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан сургалтын хөтөлбөр, цэцэрлэгийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлого болон холбогдох бусад норм, нормативыг удирдлага болгох;

3.7. Сургалтыг “Хөдөлгөөн, эрүүл мэнд”, “Хэл яриа”, “Математикийн энгийн төсөөлөл”, “Байгаль, нийгмийн орчин”, “Хөгжим”, “Дүрслэх урлаг” чиглэлээр зохион байгуулах бөгөөд чиглэл бүрийг 7 хоногт нэг удаа зохион байгуулахаар төлөвлөх;

3.8. Сургалт, үйл ажиллагааны удирдлагыг заах аргын нэгдэл, багшид мэргэжил арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх, хяналт тавих чиг үүргийг арга зүйч, эрхлэгч тус тус хэрэгжүүлэх;

3.9. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас сургалтын үйл ажиллагаанд тасалдал үүсэх тохиолдолд үндсэн сургалтыг үргэлжлүүлэн зохион байгуулах арга хэлбэрийг тодорхойлж, бэлэн байдлыг хангах;

3.10. Сургалт, үйл ажиллагаанд хүүхэд төвт сургалтын нэгдмэл арга зүй, технологийг баримтлах бөгөөд сургалтыг ганцаарчилсан, хэсэг бүлэг, анги нийтийг хамарсан хэлбэрээр зохион байгуулах;

3.10.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахад ганцаарчилсан сургалтын арга хэлбэрийг ашиглах бөгөөд энэ тохиолдолд тэдний хөгжлийн онцлог, суралцах хэв маяг, тусгай хэрэгцээнд нийцсэн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;

3.10.2. Багш чиглэлийн 3.10.1-д заасан сургалтын явцад хүүхдийг өдөр тутам ажиглаж, ахиц өөрчлөлтийг илрүүлэн түүнд тохирсон арга барил, хэрэглэгдэхүүнийг сонгож тэдний хөгжлийг дэмжих;

3.11. Сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй, бүтээлчээр хэрэгжүүлэх талаар заах аргын нэгдэл, арга зүйч, эрхлэгчээс өгсөн чиглэл, зөвлөмжид үндэслэн бүлгийн хүүхдийн нас, хөгжлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлэн багш сургалт, үйл ажиллагааны арга зүй, технологийг боловсруулж хэрэгжүүлэх;

3.11.1. “Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөр”-ийг жил /сургалт, үйл ажиллагааны хичээлийн жилийн төлөвлөгөө/, 7 хоног /1-3/, өдөр тутмын төлөвлөлтөөр тус тус хэрэгжүүлэх;

3.11.2. Сургалт, үйл ажиллагааг багш “Бүлгийн менежмент”-д тулгуурлан хэрэгжүүлэх бөгөөд өдрийн дэглэм-сургалт, үйл ажиллагаа; сургалтын орчин-аюулгүй байдал; хүртээмж-хүүхдийн бүтээлч үйл; багш-хүүхэд-эцэг эх, асран хамгаалагчийн харилцааны уялдааг тус тус хангах;

3.11.3. Хүүхэд өөрийгөө зөв илэрхийлэх, бусдыг хүндэтгэн харилцах, харилцааны хэлбэрээс хүчирхийллийг ялгаж, мэдээлэх чадвартай болох, түүх, үндэсний уламжлал, ёс заншлын талаар мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлэх агуулгыг тусгах;

3.11.4. Хүүхдэд нийгэмшихүйн чадвар, дадлыг энэхүү чиглэлийн 3.7-д заасан сургалтын чиглэл бүрээр зохион байгуулж байгаа сургалт болон өдрийн дэглэм дэх бусад үйл ажиллагааны явцад эзэмшүүлэхээр тооцож өдөр тутмын төлөвлөлтөд тусгах;

3.11.5. Хүүхдэд эрсдэлээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалах, бусдаас тусламж хүсэх, бусдад туслах мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлэхэд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан хүчин төгөлдөр мөрдөж байгаа “Аюулгүй амьдрах ухааны хөтөлбөр” дэх сургуулийн өмнөх боловсролд хамаарах агуулгыг хэрэгжүүлэх;

3.11.6. Сургалт, үйл ажиллагааны явцад хүүхдийн илэрхийлж буй хүсэлт, хэрэгцээ, сонирхол, хариу үйлдэл, эцэг эх, асран хамгаалагчийн хүсэлт, шаардлага, арга зүйч, эрхлэгчийн өгсөн зөвлөгөө, зөвлөмжийг баримтлан бүлгийн менежментийг тогтмол сайжруулах;

3.12. Цэцэрлэгийн хэв шинжээс хамааран хүүхэд хүлээн авах, тарах, хооллох, нойрсох үйл ажиллагааны хугацааг багш нарын оролцоотой тогтоож, баталгаажуулах бөгөөд түүнд нийцүүлэн бүлгийн өдрийн дэглэмийг ялгаатай төлөвлөж мөрдөх;

3.12.1. Өдрийн дэглэм дэх үйл ажиллагааны үргэлжлэх хугацаа, нэг үйл ажиллагаанаас нөгөөд шилжих шилжилтийг хүүхдийн нас, хөгжлийн онцлог, хэрэгцээг харгалзан зохион байгуулах;

3.13. Хүүхдийн хөгжлийн ахиц өөрчлөлтийг илрүүлэх, үнэлж, дүгнэхэд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан, хүчин төгөлдөр мөрдөж байгаа “Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн хөгжил болон сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх журам”-ыг баримтлах;

3.13.1. Хүүхдийн хөгжлийн ахиц өөрчлөлтийн үнэлгээний хуудас, хувийн хавтсыг хүүхэд сургуульд элсэн суралцах үед эцэг эх, асран хамгаалагчид хүлээлгэн өгөх бөгөөд эцэг эх, асран хамгаалагч түүнийг ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн багшид шилжүүлэн өгөх.

Дөрөв. Сургалт, үйл ажиллагааны хэвийн байдал, хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах

4.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас эрх бүхий байгууллагаас тогтоосон хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалт, онцгой дэглэмээс бусад тохиолдолд цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааг зогсоох, тасалдуулахыг хориглох;

4.2. Багшийг албан тушаалын тодорхойлолтод заасан үндсэн чиг үүрэгт үл хамаарах ажил, үүрэг гүйцэтгүүлэх, олон нийтийн ажилд дайчлах, сургалт, үйл ажиллагааны явцад хүүхдийг хараа хяналтгүй орхихгүй бөгөөд багш, ажилтныг хамарсан аливаа хэлбэрийн уралдаан, тэмцээн зохион байгуулахыг хориглох;

4.3. Цэцэрлэг болон ерөнхий боловсролын сургуульд элсэн суралцах хүүхдийг цэцэрлэг, сургуулийн орчинтой танилцуулах, дасан зохицох үйл ажиллагааг эцэг эх, асран хамгаалагч, сургуулийн бага ангийн сургалтын менежертэй хамтран зохион байгуулах;

4.4. Өдөр тутмын сургалт үйл ажиллагааны явцад хүүхэд өөрийн хүсэл хэрэгцээгээ чөлөөтэй илэрхийлэх, сонирхлоороо сонголт хийх, бие даан чөлөөтэй тоглох, суралцахад чиглэсэн орчин нөхцөл бүрдүүлэх;

4.5. Сургалт, үйл ажиллагааны явцад хүүхдийн авьяасыг хөгжүүлэхэд багш ганцаарчилсан дэмжлэг үзүүлэх;

4.6. Хүүхдийн хөгжлийг дэмжих, авьяасыг хөгжүүлэх аливаа сургалтыг эцэг эх, асран хамгаалагчийн албан ёсны хүсэлт, зөвшөөрөл, заах аргын нэгдлийн хурлын шийдвэрийг үндэслэн эрх бүхий байгууллага, иргэнтэй гэрээ байгуулан хэрэгжүүлж, үр дүнг тооцох;

4.7. Энэ чиглэлийн 4.6-д заасан сургалтыг зохион байгуулахад цэцэрлэг, багш болон аж ахуйн нэгж байгууллага, иргэн ашиг олох зорилгоор нийт хүүхдийг хамруулах, эцэг эх, асран хамгаалагчдад санхүүгийн дарамт учруулах, өдөр тутмын сургалт, үйл ажиллагааг тасалдуулахыг тус тус хориглох;

4.8. Хүүхдийн онцлог, хөгжлийн өөрчлөлтийн талаарх мэдээллийг бүлгийн өрөөнд ил байршуулахгүй, эцэг эх, асран хамгаалагчидтай харилцах, цахим сүлжээгээр нийтэд мэдээлэхгүй байх;

4.9. Хүүхдийг хамарсан уралдаан, тэмцээн зохион байгуулж, өрсөлдүүлэх, нийт хүүхдээс нэг болон хэсэг бүлгийг онцгойлон урамшуулж шагнах, гэрэл зургийг цэцэрлэгийн хонгил /коридор/, анги танхимд байршуулах зэргээр бага насны хүүхдэд сэтгэл зүйн сөрөг нөлөө үзүүлэхгүйц үйл ажиллагааг зохион байгуулахгүй байх;

4.10. Багш хүүхдийн хувийн дэлгэрэнгүй мэдээлэл, тэдний хэл яриа, бие бялдар, өсөлт хөгжил, эрүүл мэнд, зан чанар, сэтгэхүйн хөгжлийн онцлогийг илрүүлэх судалгаа хөтлөн, хүүхдийн хөгжлийг дэмжих, аюулгүй байдлыг хангах, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа зохион байгуулахад ашигладаг байх;

4.11. Хүүхдийн сэтгэл зүйн байдалд ажиглалт хийж, эмч болон эцэг, эх асран хамгаалагчдад мэдээлэл хүргэж, хамтран ажиллах.

Тав. Хүүхдэд ээлтэй сургалтын орчин бүрдүүлэх

5.1. Цэцэрлэгийн сургалтын эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэхэд “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчин. Ерөнхий шаардлага MNS6558:2015 стандарт”-ыг баримтлах;

5.2. Цэцэрлэгийн бага, дунд бүлгийг барилгын нэгдүгээр давхарт байрлуулахаар анги танхимын зохион байгуулалт хийх;

5.3. Сургалтын хэрэглэгдэхүүн, хэрэгсэл, тоглоом наадгай нь хүүхдийн нас, хөгжлийн онцлог, сургалтын агуулгад нийцсэн, хүртээмжтэй, бүтээлч үйлийг дэмжсэн байхаар бүрдүүлж, аюулгүй байдлыг хангах;

5.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэгт хамрагдах нөхцөлийг бүрдүүлж, тэдний тусгай хэрэгцээнд тохирох сургалтын хэрэглэгдэхүүн, туслах хэрэгсэл, тавилга, хэрэгсэл, үзүүлэн таниулах материал, тоглоом наадгайгаар хангах арга хэмжээ авах;

5.5. Бүлгийн өрөө, цэцэрлэгийн хонгил /коридор/-ын хананд сургалтад ач холбогдол багатай зураг зурах, жааз, самбар байрлуулахгүй байх;

5.6. “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчныг үнэлэх шалгуур үзүүлэлт”-ийн дагуу өөрийн үнэлгээг жил бүр, аюулгүй байдалд тодорхой давтамжтай хяналт тус тус хийж, шаардлагатай арга хэмжээ авах;

5.7. Хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх хурц үзүүртэй, шил, шаазан материал, тогтворгүй унах эрсдэлтэй эд зүйлийг анги, танхимд байрлуулах, сургалт, үйл ажиллагаанд ашиглахыг хориглох бөгөөд анги, бүлгийн тавилга эд хогшлыг унахаас урьдчилан сэргийлж бэхэлгээ хийх.

Зургаа. Багшийн мэргэжлийн хөгжлийг хангах

6.1. Бүлгийн сургалт, үйл ажиллагааны явцад арга зүйч, эрхлэгч тогтмол ажиглалт хийж, багшлахуйн үйлд гарч буй ахиц дэвшлийг үнэлэн, зөвлөгөө, дэмжлэг тусалцаа тогтмол үзүүлэх;

6.2. Багшийн мэргэжлийг дээшлүүлэх хэрэгцээний судалгаа хийж, түүнд үндэслэн багшийн мэдлэг, боловсрол, ур чадварыг ажлын байранд хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх, үр дүнг тооцох;

6.2.1 Ажлын байран дахь мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилт, агуулга тэдгээрийн залгамж холбоог судлах, бүлгийн менежментэд шинэ арга зүй, технологи турших, нэвтрүүлэх, хамтран суралцах, туршлага солилцох, түгээн дэлгэрүүлэх, сургалт, мэтгэлцээн, онол-практикийн хурал зэрэг бүтээлч үйлийг хэрэгжүүлэхэд чиглүүлэх;

6.2.2 Багш цахим технологи ашиглан эцэг эхтэй харилцах, зайнаас хүүхдийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн сургалтын арга, технологи эзэмшиж, мэдээлэл харилцааны ур чадвараа сайжруулахад дэмжлэг үзүүлэх;

6.3 Заах аргын нэгдлийн ажлыг хүүхдийн онцлог, хөгжлийн ахиц өөрчлөлтийг илрүүлэх, үнэлгээний үр дүнд шинжилгээ хийх, хүүхэд бүрд тохирсон дэмжлэг үзүүлэх сургалтын арга зүй, технологи боловсруулах, төлөвлөх, зохион байгуулахад багш бүр өөрийн үнэлгээ хийж, сайжруулах талаар хамтран хэлэлцэх, зөвлөлдөхөд чиглүүлэх;

6.4 Багшийн хөгжлийн төвийг үр дүнтэй ажиллуулан, багш мэдлэг, ур чадвараа ажлын байранд тасралтгүй дээшлүүлэх, сургалт, үйл ажиллагаа зохион байгуулахад мэдээллийн технологи, программ хангамж ашиглах боломж, орчин нөхцөлийг бүрдүүлж, түүний аюулгүй байдлыг хангах.

Долоо. Эцэг эх, асран хамгаалагчийн хамтын ажиллагааг хангах

7.1. Эцэг эх, асран хамгаалагчдад сургалт, үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөх, хүүхдийн хөгжлийг дэмжих асуудлаар зөвлөлдөх, , шийдвэр гаргах, хяналт тавихад оролцоог хангах;

7.1.1. Сургалт үйл ажиллагааны төлөвлөгөөг эцэг эх, асран хамгаалагчдад нээлттэй танилцуулж, хүүхдийн хөгжлийг гэр бүлийн орчинд дэмжих, танхимын сургалтаар эзэмшсэн мэдлэг, чадвар, дадал, хэвшлийг бататгахад чиглэсэн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд тэдний оролцоог нэмэгдүүлэхэд чиглүүлэх;

7.1.2. Эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдийн аюулгүй байдлыг хангах, осол аюул, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд тулгарч буй бэрхшээл, эрэлт хэрэгцээг судлан шийдвэрлэх, зөвлөгөө, мэдээлэл тогтмол өгдөг байх;

7.2. Хүүхэдтэй холбогдох аливаа шийдвэр гаргахад эцэг эх, асран хамгаалагчаас санал авч, хариу мэдээлэл өгдөг байх;

7.3. Багш, ажилтан нь хүүхдийн гэр бүлийн соёл, уламжлал, зан заншил, ялгаатай байдлыг хүндэтгэн харилцдаг байх.